

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/012/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn  Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn  Аудитор: Б.Хуланхатан Утас: 99008827 Цахим хаяг: khulankhatanb@audit.gov.mn  Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 495

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Төсвийн төвлөрүүлэн захирагч нь сумын ИТХ-аар батлагдсан үйл ажиллагааны орлогыг 1,180.9 мянган төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийг 22,427.9 мянган төгрөгөөр тус тус дутуу бүрдүүлсэн, тогтмол зардлын санхүүжилтийг Соёлын төвд 4,800.0 мянган төгрөг, Цэцэрлэгт 3,900.0 мянган төгрөгөөр дутуу, ЕБС-д 8,700.0 мянган төгрөгөөр илүү олгосон.
- ✓ Санхүүжих эх үүсвэрийг орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлийг 7,065.3 мянган төгрөгөөр, ОНХС-ийн үлдэгдлийг 18,172.3 мянган төгрөгөөр, ХХС-ийн үлдэгдлийг 1,080.5 мянган төгрөгөөр тус тус дутуу төлөвлөсөн.

- ✓ Тайланд оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш 331,488.3 мянган төгрөгийн 5 төсөл, арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулсан, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаас тус сумын 2-р багийн Дулаан толгод гэх газар нөхөн сэргээлт хийх ажилд тендер зарлаагүй.
- ✓ ЗДТГ-ын батлагдсан төсвөөс Эрүүл мэндийн салбарын 100 жилийн ойд 1,000.0 мянган төгрөгийн хандив өгсөн, үндэслэлгүйгээр 5,027.4 мянган төгрөгийн тэтгэмж олгосон, шуудан холбооны зардлаас байгууллагын 25 ажилтны гар утасны нэгжийн төлбөрийг төлсөн.
- ✓ ИТХ үндсэн үйл ажиллагааны зардлаас 16,807.5 мянган төгрөгийг олон нийтийн цагдаагийн урамшуулалд, 1,000.0 мянган төгрөгийг тэмцээн уралдаан зохион байгуулахад олгож, ОНХС-аас мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд шатахууны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг шүлхий өвчний дархлаажуулалтын ажлын зардалтай давхардуулан зориулалт бусаар зарцуулсан.
- ✓ Дархан тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ 1,220.0 мянган төгрөгийг хүчин төгөлдөр бус анхан шатны баримтыг үндэслэн олгосон байна.

Энэ нь дараах хууль тогтоомжийг зөрчсөн байна. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;" 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ;" 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;"
- ✓ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;"
- ✓ Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно"
- ✓ Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-д "төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох."
- ✓ Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;"
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.";
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:"; 12.1.1-д "үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал;"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах"

- ✓ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;”, 6.1.2-д “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 18 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,988,240.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,049,885.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 938,355.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,430,330.4 мянган төгрөг буюу 81.3 хувьтай байна.

#### **Аудитын гол асуудал**

Дархан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 896,883.4 мянган төгрөгийн 19 алдаа, зөрчил илэрч 35,899.3 мянган төгрөгийн 5 алдааг санхүүгийн тайланд залруулж, 7,622.4 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 828,752.8 мянган төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 24,608.8 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн болно.

Орон нутгийн төсөвт 886,100.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,175,068.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 288,968.8 мянган төгрөгөөр буюу 132.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн Долоодугаар хуралдаанаар сумын Засаг даргын 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 94.3 хувь буюу үр дүн гарсан гэж дүгнэсэн байна.

Сумын Засаг дарга нь ОНӨҮГ-ын даргаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан шаардлага хангаагүй хүнийг томилж, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1-т “дээд боловсролтой;”, 18.2.2-т “ аль нэг хуулийн этгээд буюу түүний салбар нэгжийн удирдах ажлыг 2-оос доошгүй жил хийсэн, удирдлагын зохих дадлагатай;”, 18.2.3-т “удирдлагын ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг.”, 19 дүгээр зүйлийн 19.1-д “ Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна”, 20 дугаар зүйл. 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалтыг зөрчсөн тул 1 албан шаардлага хүргүүлээ.

Орон нутгийн хөгжлийн сангаас 938,355.7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 28 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 786,771.9 мянган төгрөгийн 24 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, зөөврийн ариун цэврийн байгууламж, малчдад зориулсан сургалт сурталчилгаа, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх ажил хийгдээгүй байна.

Сумын төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөх, батлагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан****/мянган төгрөг/**

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,469,174.7	1,471,173.84
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	891,562.69	939,599.83
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	300,238.57	297,397.76
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	80,645.52	30,045.52
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	196,727.93	204,130.73
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,456,381.58	3,894,200.86
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,456,381.58	3,894,200.86
8	1.2.2.02 Биет хөрөнгө		3,428,100.33	3,849,269.56
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	28,281.25	44,931.3
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		4,925,556.28	5,365,374.7
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,005,577.55	1,181,851.4
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,005,577.55	1,181,851.4
13	2.1.1.03 Өглөг		2,656.4	64,203.85
14	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	1,002,921.16	1,117,647.55
15	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,919,978.73	4,183,523.29
16	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		3,919,978.73	4,183,523.29
17	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		457,233.74	474,874.54
18	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/		1,714.00	1,714.00
19	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		3,406,537.19	3,652,440.95
20	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		54,493.81	54,493.81
21	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		4,925,556.28	5,365,374.7

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		3,227,978.02	3,330,637.84
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		947,320.24	1,034,744.46
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		610,987.39	663,215.74
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		610,987.39	663,215.74
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		76,088.75	76,589.01
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		260,244.1	294,939.72
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	736,431.71	2,295,893.37
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		-	18,789.57
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,544,226.07	-
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,213,778.68	2,233,690.49
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		2,213,778.68	2,233,690.49
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,168,074.05	2,205,168.18
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		702,721.81	850,178.83
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		87,343.5	105,575
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		373,822.79	390,699.85
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		54,902.86	40,245.31
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		1,814.6	2,271.3
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		116,624.75	64,232.92
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		28,478	26,900
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		329,441.48	415,748.46
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		472,924.27	309,316.51
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		45,704.63	28,522.31
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,014,199.34	1,096,947.35
24	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		341,484.27	851,043.58
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(341,484.27)	(851,043.58)
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		672,715.07	245,903.77

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан****/мянган төгрөг/**

<b>№</b>	<b>Дансны нэр, төрөл</b>	<b>Засгийн газрын хувь оролцооны нийт дүн</b>	<b>Нийт цэвэр хөрөнгө /өмч</b>
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,247,263.66	3,247,263.66
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,247,263.66	3,247,263.66
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	672,715.07	672,715.07
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,919,978.73	3,919,978.73
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,919,978.73	3,919,978.73
6	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,919,978.73	3,919,978.73
7	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	17,640.8	17,640.8
8	1.7 Тайлант үеийн үр дүн	245,903.77	245,903.77
9	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,183,523.29	4,183,523.29

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,033,398.62	2,968,253.89
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	947,320.24	1,034,744.46
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	610,987.39	663,215.74
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	76,088.75	76,589.01
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	260,244.1	294,939.72
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	32,816.34	36,822.81
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	227,427.76	256,410.25
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	1,706.65
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	536,452.31	1,933,509.43
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	536,452.31	746,231.04
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	684,735.19
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	502,543.2
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,549,626.07	-
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,983,902.8	2,111,119.82
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,983,902.8	2,111,119.82
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,930,098.17	2,095,399.51
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	839,280.86	1,009,947.56
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,496.86	156,755.95
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	373,993.48	385,287.32
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	183,691.88	214,605.6
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	754.6	1,948.3
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	101,487.45	68,456.45
23	1.1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал	28,478	26,050
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	140,047.42	178,065.28
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	132,867.63	54,283.06
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,804.63	15,720.31
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,049,495.82	857,134.06
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	384,470.47	809,096.92
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	384,470.47	809,096.92
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	384,470.47	809,096.92
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(384,470.47)	(809,096.92)
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	210,000.00	-
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(210,000.00)	-
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	455,025.35	48,037.14
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	436,537.33	891,562.69
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	891,562.69	939,599.83

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,709,028.60	3,776,769.33
11	3.1.01.1.1 Татварын орлого	830,100.00	1,034,744.46
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	579,120.00	663,215.74
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	579,120.00	663,215.74
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	486,000.00	552,889.61
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	50,000.00	48,819.07
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	43,000.00	46,941.32
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	-	14,440.74
110006	3.1.01.1.1.1.1.06 Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	120.00	125.00
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	38,650.00	76,589.01
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	22,950.00	29,823.26
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	700.00	720.00
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	15,000.00	46,045.75
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	212,330.00	294,939.72
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	31,000.00	36,822.81
118001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	3,000.00	4,218.41
118006	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,000.00	-
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	27,000.00	32,604.40
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	180,000.00	256,410.25
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	180,000.00	256,410.25
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,330.00	1,706.65
118202	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,000.00	1,000.00
118203	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	330.00	706.65
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	2,878,928.60	2,742,024.87
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	157,633.60	299,505.56
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	55,000.00	60,318.06
120004	/үндсэн/	51,633.60	48,681.19
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	50,000.00	110,500.00
120009	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	1,000.00	80,006.30
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	2,218,751.80	1,939,976.11
122003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	666,325.90	666,325.90
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	1,552,425.90	1,273,650.21
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	502,543.20	502,543.20
123002	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	502,543.20	502,543.20
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН	2,988,240.90	4,119,790.59
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,965,644.60	3,333,018.67
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,941,563.10	1,631,176.46

2101	3.1.01.2.1.1.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	983,014.90	850,178.83
210101	3.1.01.2.1.1.1.01	Үндсэн цалин	389,056.80	358,626.82
210102	3.1.01.2.1.1.1.02	Нэмэгдэл	461,634.10	387,400.80
210103	3.1.01.2.1.1.1.03	Унаа хоолны хөнгөлөлт	55,040.00	43,090.00
210104	3.1.01.2.1.1.1.04	Урамшуулал	29,622.00	13,431.61
210105	3.1.01.2.1.1.1.05	Гэрээт ажлын хөлс	47,662.00	47,629.61
2102	3.1.01.2.1.1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,314.70	105,575.00
210201	3.1.01.2.1.1.2.01	Тэтгэврийн даатгал	83,993.90	72,491.16
210202	3.1.01.2.1.1.2.02	Тэтгэмжийн даатгал	9,830.10	8,502.51
210203	3.1.01.2.1.1.2.03	ҮОМШӨ-ний даатгал	4,915.20	4,240.32
210204	3.1.01.2.1.1.2.04	Ажилгүйдлийн даатгал	4,915.20	4,048.65
210205	3.1.01.2.1.1.2.05	Эрүүл мэндийн даатгал	19,660.30	16,292.36
2103	3.1.01.2.1.1.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	417,701.40	385,287.32
210301	3.1.01.2.1.1.3.01	Гэрэл, цахилгаан	62,017.50	45,977.76
210302	3.1.01.2.1.1.3.02	Түлш, халаалт	344,991.50	329,723.00
210303	3.1.01.2.1.1.3.03	Цэвэр, бохир ус	10,692.40	9,586.56
2104	3.1.01.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	47,533.30	31,500.96
210401	3.1.01.2.1.1.4.01	Бичиг хэрэг	6,731.60	1,971.20
210402	3.1.01.2.1.1.4.02	Тээвэр, шатахуун	29,331.20	21,691.33
210403	3.1.01.2.1.1.4.03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,320.00	5,035.40
210405	3.1.01.2.1.1.4.05	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,571.80	1,179.00
210406	3.1.01.2.1.1.4.06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,578.70	1,624.03
2105	3.1.01.2.1.1.5	Нормативт зардал	4,807.10	1,948.30
210503	3.1.01.2.1.1.5.03	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,807.10	1,948.30
2106	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	106,365.60	90,781.45
210601	3.1.01.2.1.1.6.01	Багаж, техник, хэрэгсэл	5,605.80	3,364.90
210602	3.1.01.2.1.1.6.02	Тавилга	20,000.00	15,770.10
210603	3.1.01.2.1.1.6.03	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943.10	-
210604	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	79,816.70	71,646.45
2107	3.1.01.2.1.1.7	Томилолт, зочны зардал	27,200.00	22,870.00
210702	3.1.01.2.1.1.7.02	Дотоод албан томилолт	27,200.00	22,870.00
2108	3.1.01.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	140,073.30	93,515.62
210801	3.1.01.2.1.1.8.01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	134,606.40	90,663.15
210802	3.1.01.2.1.1.8.02	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	961.70	-
210803	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	1,014.30	1,014.30
210804	3.1.01.2.1.1.8.04	Тээврийн хэрэгслийн татвар	536.40	312.56
210805	3.1.01.2.1.1.8.05	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245.60	132.00
210806	3.1.01.2.1.1.8.06	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,745.40	1,340.40
210807	3.1.01.2.1.1.8.07	Газрын төлбөр	963.50	53.22
2109	3.1.01.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	91,552.80	49,518.98
210901	3.1.01.2.1.1.9.01	Бараа үйлчилгээний бусад зардал	77,953.90	42,942.88
210902	3.1.01.2.1.1.9.02	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,598.90	6,576.10
213	3.1.01.2.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,081.50	1,701,842.21
2131	3.1.01.2.1.4.1	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,689,457.21
213103	3.1.01.2.1.4.1.03	Төсвийн санхүүжилт	-	1,689,457.21
2132	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	24,081.50	12,385.00
213209	3.1.01.2.1.4.2.08	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,081.50	12,385.00

22	3.1.01.2.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	938,355.70	786,771.92
223001	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	938,355.70	786,771.92
23	3.1.01.2.3	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	84,240.60	-
230001	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	84,240.60	-
8	3.1.01	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	720,787.70	(343,021.27)
9	3.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(720,787.70)	343,021.27
7	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(720,787.70)	343,021.27
4	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	857,956.35
5	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	930,742.08

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
<b>1</b>	<b>1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>18,409.29</b>
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,409.29
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	18,409.29
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	18,409.29
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	18,409.29
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,185.60
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,223.69
<b>II</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>15,298.98</b>
<b>21</b>	<b>1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>15,298.98</b>
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,298.98
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	6,056.22
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	6,056.22
2107	1.1.1.2.1.1.7 Томилолт, зочны зардал	3,180.00
210702	1.1.1.2.1.1.7.2 Дотоод албан томилолт	3,180.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,298.68
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,298.68
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	4,764.08
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	1,022.40
210902	1.1.1.2.1.1.9.2 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,741.68
<b>4</b>	<b>1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>3,110.31</b>
<b>5</b>	<b>1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(3,110.31)</b>
<b>6</b>	<b>1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>(3,110.31)</b>

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Дархан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 6 байгууллага, 1 төрийн сан, 2 тусгай сан, 1 орон нутгийн өмчит нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллагын санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

Аймаг дахь Төрийн аудитын газар Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд, “Платиниум прогресс аудит” ХХК Эрүүл мэндийн төв, “Ари файнэнс аудит” ХХК Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн.

### **3.1 Тус сумын харьяа орон нутгийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:**

Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 490,970.1 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илрүүлснээс 29,761.3 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 7,622.4 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 453,586.4 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

#### **Иргэдийн төлөөлөгчдийн хурал**

1. Үндсэн үйл ажиллагааны зардлаас 16,807.5 мянган төгрөгийг олон нийтийн цагдаагийн урамшуулалд олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*

2. Байгууллагын ахмадын сангаас сумын ахмадын баярын спортын уралдаан, тэмцээний хоол, буудлын зардалд 1,000.0 мянган төгрөг зарцуулсан.

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*

#### **Засаг даргын тамгын газар**

1. Байгууллагын нэр дээр эзэмших эрхийн гэрчилгээтэй 17,640.8 мянган төгрөгийн газрыг үнэлж, бүртгэж авахдаа, үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасныг аудитын явцад санхүүгийн тайланд засгийн газрын оруулсан капитал дансыг нэмэгдүүлж залруулав.

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*

2. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаас 29,000.0 мянган төгрөгөөр тус сумын 2-р багийн Дулаан толгод гэх газар нөхөн сэргээлт хийх ажилд тендер зарлаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.*

3. Шуудан холбооны зардлаас байгууллагын 25 ажилтанд 375.0 мянган төгрөгийн гар утасны нэгж олгосон байна.

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.*

4. Батлагдсан төсвөөс Эрүүл мэндийн салбарын 100 жилийн ойд 1,000.0 мянган төгрөгийн хандив өгсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.*

5. Батлагдсан төсвөөс анхан шатны баримтын бүрдэлгүй, үндэслэлгүйгээр 5,027.4 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

### **Орон нутгийн хөгжлийн сан**

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн "Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх" төсөл, арга хэмжээний хүрээнд улсын төсвөөс санхүүжүүлдэг шүлхий өвчний тарилгын ажил гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд 1,522.5 мянган төгрөгийн шатахууны зардал олгож хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*

2. Шилэн дансны Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл хэсэгт 405,256.4 мянган төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг мэдээлээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*

### **Хоршоо хөгжүүлэх сан**

1. Зээлийн хүүгийн авлагын 11,812.6 мянган төгрөгийг санхүүгийн тайланд зээлийн авлагаар бүртгээснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

### **Дархан тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ**

1. НДШ-ийн тайлангаар баталгаажуулсан 307.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсныг залруулав.
2. Тайлант онд 3 ажилтанд 540.0 мянган төгрөгийн албан томилолт илүү тооцож, 2 ажилтанд 680.0 мянган төгрөгийн албан томилолтыг хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, нийт 1,220.0 мянган төгрөгийн албан томилолт олгосон байна.

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.*

### **3.2 Тус сумын харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:**

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 103,101.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 82,511.0 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 1,220.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 19,370.4 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

### **Соёлын төв**

1. Сургалтын зардалд 200.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч сургалт хийсэн тухай баримтгүй, албан хаагчдад 680.0 мянган төгрөгийн албан томилолтыг олгосон боловч илтгэх хуудас, удирдамжгүй, 5,304.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг гэрээ байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн зэрэг нийт 6,700.9 мянган төгрөгийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан байна.

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*

### **Ерөнхий боловсролын сургууль**

1. Газар эзэмших эрхийн /0000363296/ дугаар бүхий гэрчилгээтэй 12248 м.кв газрыг нягтлан бодох бүртгэлд 11048 м.кв-аар буюу 82,096.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулав.
2. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүй 14 ажилтанд 25 хувиар тооцож 8,802.8 мянган төгрөгийг олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

3. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх өөрийн хөрөнгийн хэмжээ санхүүгийн тайлан дахь Засгийн газрын өмчийн дүн зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

### **Хүүхдийн цэцэрлэг**

1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтийг нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй тайлангаас 86.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг аудитын явцад залруулав.
2. Цалингийн зардлыг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 328.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулав.
3. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 52 нэр төрлийн (анхны өртөг 35,958.6 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг дахин үнэлж, бүртгэлд тусгах зөвлөмж өгсөн.

4. Ур чадварын нэмэгдлийг журмын дагуу хагас жил тутам холбогдох шалгуур үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнэлгүйгээр 13 албан хаагчид тухайн үеийн амжилтыг харгалзан 3,866.7 мянган төгрөг олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

5. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх өөрийн хөрөнгийн хэмжээ санхүүгийн тайлан дахь Засгийн газрын өмчийн дүн зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

6. Хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг зохион байгуулсан боловч тооцоо бодсон акт үйлдээгүй, үлдээдлийг баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

### **Эрүүл мэндийн төв**

1. Тайлант онд гурван ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 343.8 мянган төгрөгийн цалин, мөн Сумын засаг даргын 2 удаагийн захирамжийн дагуу эрхлэгч, нягтлан бодогч, нярав нарт 876.4 төгрөгийн урамшуулал, нийт 1,220.2 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

### **3.3 Сумын засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:**

Дархан сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 6,138.0 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланд залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн нэгтгэсэн төсвийн үр дүнгийн тайланд нэмэлт санхүүжилтийн орлогыг 1,800.2 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн.
2. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд замд яваа мөнгө 4,337.8 мянган төгрөгийг тусгаагүй байна.

Аудитаар нийт 399,775.3 мянган төгрөгийн 5 зөрчил илэрч, 24,608.8 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 375,166.5 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ.

#### **3.3.1 Төлбөрийн акт**

*Байхгүй.*

#### **3.3.2 Албан шаардлага**

1. *Тайланд оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш 331,488.3 мянган төгрөгийн 5 төсөл, арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулсан.*
2. *Сумын ИТХ-аар баталсан тогтмол зардлын санхүүжилтийг Соёлын төвд 4,800.0 мянган төгрөг, Цэцэрлэгт 3,900.0 мянган төгрөгөөр дутуу, ЕБС-д 8,700.0 мянган төгрөгөөр илүү олгосон.*
3. *Тайлант онд төсвийн тодотгол 1 удаа хийсэн боловч урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлийг 7,065.3 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдлийг 18,172.3 мянган төгрөг, ХХС-ийн үлдэгдлийг 1,080.5 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн.*
4. *Сумын Засаг дарга нь ОНӨҮГ-ын даргаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан шаардлага хангаагүй хүнийг томилж, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй байна.*

#### **3.3.3 Зөвлөмж**

1. *Үйл ажиллагааны орлогыг 1,180.9 мянган төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийг 22,427.9 мянган төгрөгөөр тус тус дутуу бүрдүүлсэн байна.*

**Өгсөн зөвлөмж:** *Сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлж байх.*

**Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	17,640.8			1	17,640.8	1	17,640.8				
ХХС	1	11,812.6			1	11,812.6	1	11,812.6				
Дархан тохижилт	1	307.9	1	307.9			1	307.9				
<b>ОН-ын дүн</b>	<b>3</b>	<b>29,761.3</b>	<b>1</b>	<b>307.9</b>	<b>2</b>	<b>29,453.4</b>	<b>3</b>	<b>29,761.3</b>	-	-	-	-
СӨБ	2	415.0			2	415.0	2	415.0				
ЕБС	1	82,096.0			1	82,096.0	1	82,096.0				
<b>УТ-ын дүн</b>	<b>3</b>	<b>82,511.0</b>	-	-	<b>3</b>	<b>82,511.0</b>	<b>3</b>	<b>82,511.0</b>	-	-	-	-
Дархан ЗД	2	6,138.0	1	4,337.8	1	1,800.2	2	6,138.0				
<b>ТТЗ-ын дүн</b>	<b>2</b>	<b>6,138.0</b>	<b>1</b>	<b>4,337.8</b>	<b>1</b>	<b>1,800.2</b>	<b>2</b>	<b>6,138.0</b>				
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>118,410.3</b>	<b>2</b>	<b>4,645.7</b>	<b>6</b>	<b>113,764.6</b>	<b>8</b>	<b>118,410.3</b>	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан		Хууль, хяналтын байгууллагад		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ИТХ	1	16,807.5			1	16,807.5							
ЗДТГ	2	6,027.4	2	6,027.4									
ОНХС	1	1,522.5			1	1,522.5							
Дархан тохижилт	1	1,220.0	1	1,220.0									
<b>ОНБ-ын дүн</b>	<b>5</b>	<b>25,577.4</b>	<b>3</b>	<b>7,247.4</b>	<b>2</b>	<b>18,330.0</b>	-	-	-	-	-	-	-
Соёл	1	6,700.9			1	6,700.9							
СӨБ	4	3,866.7			3	3,866.7	1	-					
ЭМТ	1	1,220.2	1	1,220.2									
ЕБС	2	8,802.8			2	8,802.8							
<b>УТБ-ын дүн</b>	<b>8</b>	<b>20,590.6</b>	<b>1</b>	<b>1,220.2</b>	<b>6</b>	<b>19,370.4</b>	<b>1</b>	-	-	-	-	-	-
Дархан ЗД	3	68,326.9			2	43,718.1	1	24,608.8					
<b>ТТЗ-ын дүн</b>	<b>3</b>	<b>68,326.9</b>	-	-	<b>2</b>	<b>43,718.1</b>	<b>1</b>	<b>24,608.8</b>	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>16</b>	<b>114,494.9</b>	<b>4</b>	<b>8,467.6</b>	<b>10</b>	<b>81,418.5</b>	<b>2</b>	<b>24,608.8</b>	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
ОНХС	1	405,256.4					1	405,256.4	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>405,256.4</b>					<b>1</b>	<b>405,256.4</b>	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
ИТХ	1	1,000.0					1	1,000.0	
ЗДТГ	2	29,375.0			1	375.0	1	29,000.0	
<b>ОНБ-ын дүн</b>	<b>3</b>	<b>30,375.0</b>			<b>1</b>	<b>375.0</b>	<b>2</b>	<b>30,000.0</b>	-
		-							
<b>УТБ-ын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Дархан ЗД	2	331,448.3					2	331,448.3	
<b>ТТЗ-ын дүн</b>	<b>2</b>	<b>331,448.3</b>					<b>2</b>	<b>331,448.3</b>	
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>767,079.7</b>			<b>1</b>	<b>375.0</b>	<b>5</b>	<b>766,704.7</b>	-

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	6	4	2		4			
2	ОНТС	2		2					
3	ОНӨҮГ	1		1					
4	ТТЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>10</b>	<b>5</b>	<b>5</b>		<b>4</b>	<b>1</b>		



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 24

Дугаар 257-А/2370452

Чингис хот

ХЭА-2026/012/НА-СТА-ТТЗ

**Зөрчлийг таслан зогсоох тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг дарга нь орон нутгийн ерөнхий орлогын дансны урьд оны үлдэгдлээс 7,065,318.00 (долоон сая жаран таван мянга гурван зуун арван найман) төгрөг, ОНХС-ын үлдэгдэл 18,172,314.00 (арван найман мянга нэг зуун далан хоёр мянга гурван зуун арван дөрвөн) төгрөг, ХХС-ийн үлдэгдэл 1,080,491.00 (нэг сая наян мянга дөрвөн зуун ерэн нэгэн) төгрөгийг тус тус бүрэн төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;" 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:" 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Г.Батболд-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.ХУЛАНХАТАН



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 24

Дугаар 258-А2370452  
ХЭА-2026/012/НА-СТА-ТТЗ <sup>Чингис хот</sup>

**Зөрчлийг таслан зогсоох тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ИТХ-аар баталсан тогтмол зардлын санхүүжилтийг Соёлын төвд 4,800,000.00 (дөрвөн сая найман зуун мянган) төгрөг, Цэцэрлэгт 3,900,000.00 (гурван сая есөн зуун мянган) төгрөгөөр дутуу, ЕБС-д 8,700,000.00 (найман сая долоон зуун мянган) төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-д "төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу олгодоггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Г.Батболд-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР  
Б.ХУЛАНХАТАН



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 24

Дугаар 259-А2370452

Чингис хот

ХЭА-2026/012/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг дарга нь ОНӨҮГ-ын даргаар хуульд заасан шаардлага хангаагүй хүнийг томилж, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1-т "дээд боловсролтой", 18.2.2-т " аль нэг хуулийн этгээд буюу түүний салбар нэгжийн удирдах ажлыг 2-оос доошгүй жил хийсэн, удирдлагын зохих дадлагатай", 18.2.3-т "удирдлагын ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг.", 19 дүгээр зүйлийн 19.1-д " Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна", 20 дугаар зүйл. 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. ОНӨҮГ-ын даргаар хуульд заасан шаардлага хангаагүй хүнийг томилсон, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг баталдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Г.Батболд-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.ХУЛАНХАТАН



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 24

Дугаар 260-А2370452

Чингис хот

ХЭА-2026/012/НА-СТА-ТТЗ

Г Зөрчлийг таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш 331,448,334.00 (гурван зуун гучин нэгэн сая дөрвөн зуун дөчин найман мянга гурван зуун гучин дөрвөн) төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Г.Батболд-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.ХУЛАНХАТАН